



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Тайлан хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА...../Д.ДЭЛГЭРСАЙХАН/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)

Төлөвлөгөө бичсэн:

Төсвийн Шууд захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА...../Б.ТӨРХҮҮ/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛСИЙН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /"Алсын хараа-2050" зорилт 5.3, 7.4, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 5.3, 7.4, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.1/ Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, УБЕГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хэнтий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр "Хэтийн Хэнтий 2024"							
Зорилт 1.Зорилт 1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.							
1.1	Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын ажлыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангах.	Улсын төсөв 1.170,0 сая.төг	-Барилга угсралт, засал, тохижилтын ажлын гүйцэтгэлд хяналт тавих; -Төсөвт тусгагдсан санхүүжилтыг олгосон байх; -Улсын комисст хүлээлгэн өгөх, барилгыг ерөнхий гүйцэтгэгчээс хүлээн авах. -Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	- Хэнтий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүргэсэн.	-Төсөвт тусгагдсан санхүүжилтийг олгосон байна; -Улсын комисст хүлээлгэн өгөх, барилгыг ерөнхий гүйцэтгэгчээс хүлээн авсан байна.	Шинэ барилгын барилга угсралтын ажил гүйцэтгэх "Мандалт Констракшн" ХХК нь барилгын ажлын явц 50 хувьтай гүйцэтгэж байна.	100%
1.2	Архивын эх нотлох баримт хадгалах, төмөр тавиур, нягтаршуулсан шүүгээгээр хангах	Орон нутгийн төсөв 40,0 сая	-Нягтаршуулсан шүүгээгээр хангагдсан эсэх	-	- Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.	39.200.000 төгрөгийн архивын эх нотлох баримт хадгалах, төмөр тавиур, нягтаршуулсан шүүгээний төсвийн судалгаа гаргасан. /Хугацаа болоогүй/	50%

1.3	Эд хөрөнгийн эрхийн улсын Улсын бүртгэлийн цогц үйлчилгээг сумдад хүргэх.	Орон нутгийн төсөв 2 сая	-Сумдад үзүүлсэн үйлчилгээний тоо,	Орон нутгийн иргэдэд газрын харилцаа, улсын бүртгэлийн цогц үйлчилгээг газар дээр нь түргэн шуурхай, нээлттэй ил тод хүргэж иргэд олон нийтэд газрын харилцааны , улсын бүртгэлийн чиглэлээр үзүүлж байгаа ажил үйлчилгээг сурталчилж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг 514 иргэнд үзүүлж , өмчлөх эрхийн 473 гэрчилгээг газар дээр нь олгож, нийт 1211 иргэнд бүртгэлийн болон газрын харилцааны талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн.	Улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд хүртээмжтэй хүрсэн байна.	<p>-Хэнтий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний 4.3.4-д зааснаар энэхүү арга хэмжээний хүрээнд ГХБХБГ газартай хамтран “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цогц үйлчилгээ- Нээлттэй газрын харилцаа” өдөрлөгийг зохион байгуулах ажлын удирдамж, 15 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.</p> <p>Хэнтий аймгийн 10 сум 1 тосгонд хэрэгжилтийг хангаж ажиллалаа.</p> <p>1. Тус өдөрлөгөөр Монгол Улсын Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Улсын бүртгэлтэй холбоотой хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох журам, зааврыг хэрэгжүүлэн орон нутгийн иргэдэд газрын харилцаа, улсын бүртгэлийн цогц үйлчилгээг газар дээр нь түргэн шуурхай, нээлттэй ил тод хүргэж иргэд олон нийтэд газрын харилцааны , улсын бүртгэлийн чиглэлээр үзүүлж байгаа ажил үйлчилгээг сурталчилж, эд хөрөнгийн эрхийн улсын</p>	100%
-----	---	--------------------------	------------------------------------	--	---	---	------

						бүртгэлийн үйлчилгээг 151 иргэнд үзүүлж , өмчлөх эрхийн 111 гэрчилгээг газар дээр нь олгож, нийт 294 иргэнд бүртгэлийн болон газрын харилцааны талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн, .	
1.4	Тоон гарын үсэг олгох бэлтгэл ажлыг ханган ажиллах.	-	-Бэлтгэл ажлыг бүрэн хангасан байх Иргэнд олгох үндэсний тоон гарын үсгийг нэвтрүүлсэн байх	-Эрхзүйн орчин бүрдсэн байна.	Иргэний цахим үнэмлэхэд бичих тоон гарын үсгийг нэвтрүүлсэн байна.	-Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөний дагуу 2022.04.01-ний өдөр “Танилцуулах сургалт”-ад хамрагдсан. 2022.04.14-15 өдрүүдэд сургагч багшийг бэлтгэх сургалтад иргэний улсын ахлах бүртгэгч, мэдээллийн технологийн ажилтан нар хамрагдаж мэдээлэл олж авсан. 2022.05.02-ны өдрөөс тоон гарын үсгийг хэлтэст, 2022.05.09-ний өдрөөс сумдад олгож эхэлсэн. Тайлангийн хугацаанд Цахим гарын үсэг олгох аяныг зохион байгуулж аймгийн хэмжээнд 2377 иргэний хүсэлтээр тоон гарын үсэг олгоод байна. Үүнээс тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх зорилгоор төрийн байгууллагуудад очиж тухайн байгууллагын албан хаагчдад цахим гарын үсгийн тухай хуулийн товч мэдээлэл өгч, тоон гарын үсгийг газар дээр нь олгож ажилласан. Энэхүү ажлын	100%

						хүрээнд 361 албан хаагчид тоон гарын үсэг олгосон. Мөн зүүн бүсийн худалдааны төвд 2022.05.20-ны өдөр "Нээлттэй өдөрлөг зохион байгуулж, энэхүү өдөрлөгөөр 261 иргэнд цахим гарын үсгийн танилцуулга өгч, тоон гарын үсэг олгосон байна. Цаашид тоон гарын үсгийн олголтыг эрчимжүүлэх зорилгоор тус аймгийн төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагуудын дарга нарт урилга хэвлүүлэн хүргүүлж албан хаагчдаа хамруулахыг уриалж ажилласан.	
1.5	Энгийн гадаад паспортанд бичилт хийх ажлыг олон нийтэд сурталчилах.		Хэвлэсэн гадаад паспортын тоо	2021 онд 168 гадаад паспорт олгосон байна.	Үндэсний гадаад паспортанд бичилт хийх ажлыг эхлүүлсэн байна.	Энэ оны 2 дугаар улирлын байдлаар тус хэлтэс нь 158 иргэнд үндэсний энгийн гадаад паспортын захиалга авч, олгох ажлыг зохион байгуулсан. 2021.01.01-ний өдрөөс 2022.04.29-ний өдрийн хооронд олгосон 284 үндэсний энгийн гадаад паспортын е-дугаар мэдээллийн санд шивэгдсэн эсэхийг нягтлан шалгаж 52 бүртгэлийн е-дугаарын нөхөн оруулсан.	100%
						Хэлтсийн үйлчилгээний танхим болон Хэрлэн, Бор-	100%

1.6	Үйлчилгээний төлбөр, хураамжийг Киоск машинаар авах нөхцлийг бүрдүүлж, сурталчилан ажиллах	-	-Цахим машин, төлбөрийн системээр хийгдсэн төлбөр хураамжийн тоо; -Сурталчилсан байдал	2020 онд И-баримт апп-345, Киоск цахим төлбөрийн машинаар 1992 бүртгэлийн үйлчилгээ нийт 2337 иргэн үйлчилгээ авсан	Цахим хэлбэрээр төлбөр төлсөн иргэдийн тоо нэмэгдсэн байна.	Өндөр сумын нэг цэгийн үйлчилгээний төвд “ГЭРЭГЭ” киоск төлбөрийн машин ажиллуулж байгаа бөгөөд иргэний улсын бүртгэлтэй холбоотой төлбөр хураамжийг 3244 иргэн тус машинаар төлж үйлчилгээ авсан байна. Эд хөрөнгийн улсын бүртгэл 1296, Хуулийн этгээдийн улсын бүртгэл 398, Иргэний улсын бүртгэл 1550 үйлчилгээг үзүүлж 3 576 607 төгрөгийн орлогыг Улсын төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлээд байна.	
1.7	Байгууллагын үйл ажиллагаа , үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэн , цахим орчинд сурталчилан олон нийтэд хүргэх	-	Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан тоо;	2021 онд Хэлтсийн инфографик мэдээллийг сар бүр бэлтгэж олон нийтэд мэдээллэж ажилласан.	Сар бүр мэдээлэл байршуулсан байна. Инфографик мэдээллийг бэлтгэж цахим хуудаст байршуулсан байна..	2022 оны сар бүрийн бүртгэлийн тоон үзүүлэлтийг тухай бүр цахим хэлбэрээр хэлтсийн веб хуудас болон цахим хуудсанд байршуулсан. Мөн цаасан хэлбэрээр үйлчилгээний зааланд байршуулсан.	100%

Зорилт 2. 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.

2.1	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтлөх.	-	-Бүртгэлийн тоо;	Өмнөх онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2451, хуулийн этгээдийн УБ-ийн чиглэлээр 617, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 5509 бүртгэл хийгдсэн.	Улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд хүртээмжтэй хүрсэн байна.	Иргэний улсын бүртгэлийн нийт 2918 бүртгэл бүртгэсэн. Үүнд: төрсний 554, гэрлэсний 136, гэрлэлт дуусгавар болсны 24, үрчилсний 13, овог, нэр өөрчилсний 25, эцэг тогтоосны 40 нас барсны 185, иргэний үнэмлэхийн олголт 1245, гадаад паспортын 158, шилжилт хөдөлгөөний бүртгэл 690 тус тус зохих журмын дагуу бүртгэж санд тусгаж баталгаажуулсан. Иргэний улсын бүртгэлтэй холбоотой 4454 лавлагаа олгосон байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр: үйлчилгээ авах нийт 3993 мэдүүлэг хүлээн авч 3946 бүртгэл хийсэн. Үүнээс төрөөс үнэгүй хувьчилсан газрын бүртгэл 940 , газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл-120, шинэ орон сууцны бүртгэл-41, төрөөс үнэгүй хувьчилсан орон сууц-104 өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсгэх-17, өмчлөх эрх шилжих гэрээ-692, бүртгэлд өөрчлөлт оруулах-140, барьцааны гэрээ-1873, барьцааны гэрээ дуусгавар -885, бусад бүртгэл 2, иргэн хуулийн этгээдэд 141	100%
-----	--	---	------------------	--	---	---	------

						<p>лавлагаа мэдээллийг олгож эд хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажилласан.</p> <p>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 546 бүртгэл бүртгэгдсэн байна. Үүнд:</p> <p>Шинээр байгуулсан хуулийн этгээд – Нийт: 45</p> <ul style="list-style-type: none"> - ХХК- 53 - ТББ-9 - ЗГБХНөхөрлөл-9 - Хоршоо-3 - ҮЭБ-2 - ОНӨААТҮГ-1 <p>-Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт – 412</p> <p>-Оноосон нэрийн баталгаажуулалт –15</p> <p>-Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны хуудас – 25</p> <p>-Хураан авсан тамга- 16 тус тус бүртгэгдсэн байна.</p>	
2.2	“E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг сурталчилан ажиллах.	-	Цахим булангаар үйлчилгээ авсан иргэдийн тоо	2021 онд Цахим булангаар 107 иргэн үйлчилгээ авсан .	Цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо нэмэгдсэн байна.	<p>Үйлчилгээний зааланд ажиллуулж байгаа “E-mongolia” булангаар 59 иргэн үйлчилгээ аваад байна. Улсын бүртгэгч нар өдөр тутамдаа цахим булангаар үйлчлүүлэх иргэдэд зааварчилгаа өгч ажилласан.</p> <p>3 аж ахуйн нэгжид лавлагаа гаргаж өгсөн.</p>	100%
2.3		-				<p>-Шинэ төрсөн 554 хүүхдийн регистрийн дугаарыг төрсөн</p>	100%

	<p>Улсын бүртгэлийн асуудлаар төрийн болон бусад байгууллагатай дундын мэдээлэлийн санг ашиглан харилцан мэдээлэл солилцох.</p>		<p>-Эрүүл мэндийн байгууллагаас төрөлтийн мэдээллийг солилцох ажлыг үргэлжлүүлэх. - ГЗБГЭЗЗГ-ын Э дугаарын мэдээллийг солилцох ажлыг үргэлжлүүлэх</p>	<p>Төрийн болон бусад 9 байгууллагатай хамтран ажилласан</p>	<p>Регистрийн дугаарыг үнэн зөв олгоход хяналт тавьсан байна. ГЗБГЭЗЗГ-д Э дугаар цахимаар олгосон байна.</p>	<p>тухай эмнэлгийн гэрчилгээнд тусгагдсан мэдээлэлтэй тулган бүртгэлийг хөтөлсөн. -Хэнтий аймаг дахь хүний эрхийн комиссын шинжээчтэй хамтран хүний эрх, жендэрийн сургалтуудыг 2 удаа зохион байгуулсан. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд төрийн тусгай хүчний байгууллагууд /Цагдаагийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хорих 419 дүгээр анги/-тай хамтран тэдгээрийн албан хаагчдад тоон гарын үсэг олгох ажлыг хамтран зохион байгуулсан. Байгууллагын үйл ажиллагаа, олон нийтэд чиглэсэн ажлыг сурталчлах, танилцуулах чиглэлээр орон нутгийн хэвлэл, мэдээллийн газрууд /Өндөрхаан телевиз, GT time сэтгүүлийн редакц/-тай хамтран ажиллаж байна.</p> <p>УБЕГ-ын ЭХЭУБГ-ын 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 6/6841 дугаар чиглэлийн дагуу иргэн</p>	
--	---	--	---	--	---	---	--

						хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор газар эзэмших, ашиглах эрхийн улсын улсын бүртгэлийн дугаар / “Э”, “А” /-ыг дундын мэдээллийн сангаар дамжуулан автоматаар 890 дугаар олгож, газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой мэдээллийн хуудсыг үг системээс хэвлэн хадгаламжийн нэгж болгон архивт хадгалсан.	
2,4	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг сурталчлан ажиллах	-	-Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо; -Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо	-Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийг хөгжүүлсэн, 5 удаа тестлэн алдааг засуулсан. -Системийг ашиглах улсын бүртгэгч нарт зориулсан гарын авлага боловсруулсан.	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэсэнээр иргэн, хуулийн этгээд, банк санхүүгийн байгууллагад хүргэх төрийн үйлчилгээ түргэн шуурхай, хялбар болсон байна.	УБЕГазар нь цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд барьцааны гэрээ, түүнд нэмэлт өөрчлөлт, барьцааны гэрээг дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх, эрхийн улсын бүртгэл бүртгэх үйл ажиллагааг хөнгөн шуурхай, хялбар болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд аймгийн хэмжээнд УБЕГазрын даргын 2022 оны А/427 дугаар тушаалаар “Барьцааны гэрээ/ ипотека/г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт / ЭУБ-06 маягт/”-д өөрчлөлт оруулан,	100%

						“Барьцааны гэрээ /ипотек/-ний нэмэлт өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-13 маягт/”-ийн загварыг шинээр батлан 2022 оны 06 дугаар сарын 02-ноос мөрдөж үйл ажиллагаа явуулж буй 3 банк 5 банк бус байгууллагын холбогдох албан тушаалтнуудад мэдээлэл өгч барьцааны гэрээ, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгээд байна.	
2.5	Нотариатчийн мэдээллийн сантай холбогдон, илгээсэн мэдээллийг хүлээн авах, бүртгэх,		-Гэрээний хэрэгжилтийн хувь; Бүртгэлийн тоо -Дундын мэдээллийн сангаар мэдээллийг хүлээн авах , бүртгэх	2021 онд УБЕГ Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны “журам”-ын хүрээнд аймгийн хэмжээнд 3 нотариатчтай гэрээ байгуулж, системд нэвтрэх эрх олгосон.	Дундын мэдээллийн сангаар дамжуулан нотариатын нийлүүлсэн мэдээллийг тухай бүр шалгаж, бүртгэсэн байна..	Тайлангийн хугацаанд тус аймгийн 3 нотариатч нар нь УБЕГазартай Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээг шинэчлэн байгуулаагүй. Хууль болон гэрээнд заасны дагуу нотариатч гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдэх гэрээ, хэлцлийг дундын мэдээллийн сангаар дамжуулан бүртгэлийн байгууллагад илгээгээгүй байна.	100%
2.6	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлж эхлэх бэлтгэл ажлыг хангах.	-	- Суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх бүртгэгчийг мэргэжил аргазүйгээр хангах, - Ажлын байрны болон программын сургалтад хамруулах -Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн	2021 онд сумдын бүртгэгч нараас эрхзүйч мэргэжилтэй, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл шилжүүлэх боломжтой, сүлжээ орсон сум, бүртгэгч нарын ашигладаг и-мэйл хаягийн судалгааг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.	Алслагдсан сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулсан байна.	УБЕГазрын даргын 2021 оны 11 дүгээр 01-ний өдрийн Б/ 511 дугаар тушаалаар Хэнтий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Өмнөдэлгэр сумын улсын бүртгэгч Б.Ууганцэцэг, 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Б/701 дугаар тушаалаар Норовлин сумын улсын	100%

			үйлчилгээг суманд үзүүлж эхлэх;	Дээрхи судалгаанд хамрагдс ан 8 сумдын улсын бүртгэгч нар сумаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд нэгж дэх улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын улсын бүртгэлийн чиглэлийн хуульзүйн мэдлэг олгох тусгай хөтөлбөрт сургалтад хамрагдаж цахим шалгалтыг амжилттай өгсөн.		бүртгэгч С.Саранцэцэг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгосонтой холбоотойгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлж эхэлсэн. Эхний хагас жилийн байдлаар Бор-Өндөр, Өмнөдэлгэр, Норовлин суманд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн-208, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл- 305 нийт 513 эд хөрөнгийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. Бүртгэлийн 35 хувийг барьцааны гэрээ эзэлж байна. Сумын улсын бүртгэгч нараар дамжуулан дадлагажуулан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө чиглэлээр хангаж,орон нутгийн иргэдийг аймгийн төв ирүүлэхгүйгээр 364 нотлох баримтыг хүлээн авч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, бэлтгэл ажлыг зохион байгуулж ажилласан.	
2.7		-		2021 онд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хууль хяналтын байгууллагад 702, иргэний		- Иргэний улсын бүртгэлтэй холбоотой 4454 лавлагаа олгосон байна. Үүнд: Холбогдох хууль журмын	100%

	<p>Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх</p>		<p>Улсын бүртгэлтэй холбоотой олгосон мэдээлэл, лавлагаа, нотлох баримтын тоо; -Эрхийн улсын түтгэлзүүлсэн бүртгэлийн тоо;</p>	<p>хүсэлтээр 5984, албан хэрэгцээнд 297 лавлагаа, мэдээлэл тус тус олгосон. Үүнээс үрчлэлтийн бүртгэлтэй холбоотой 43 лавлагааг иргэнд олгосон байна Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Цагдаагийн газар, Шүүх, Прокурор зэрэг эрх бүхий байгууллагад 74 албан бичгээр 108 иргэн, хуулийн этгээдийн хөрөнгөтэй эсэх лавлагаа олгож, Хэнтий аймгийн СДИХАШШүүхэд шүүгчийн захирамжаар 2 удаа нотлох баримтыг гаргаж хүргүүлсэн.- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:Цахим мэдээллийн сангаас эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтийг үндэслэн нийт 28 лавлагаа мэдээллийг хуульд заасан хугацаанд олгож ажилласан</p>	<p>Улсын бүртгэлтэй холбоотой үнэн зөв лавлагаа, мэдээлэл, нотлох баримтыг хуульд заасан хугацаанд олгосон байна.</p>	<p>дагуу хууль хяналтын байгууллагад хүсэлт албан бичгийн дагуу иргэний улсын бүртгэлтэй холбоотой 494 лавлагаа, иргэний хүсэлтээр иргэний улсын бүртгэлтэй холбоотой 3762 лавлагаа, иргэний улсын бүртгэл хөтлөхдөө албан хэрэгцээнд зориулж 198 лавлагааг тус тус олгосон.</p> <p>-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Цагдаагийн газар, Шүүх, Прокурор зэрэг эрх бүхий байгууллагад 91 албан бичгээр 148 иргэн, хуулийн этгээдийн хөрөнгөтэй эсэх лавлагаа олгосон, ШШГГазраас ирүүлсэн 54 хөрөнгийн эрх түдгэлзүүлэх болон сэргээх тогтоолыг үндэслэн 69 эд хөрөнгөнд эрх түдгэлзүүлэх болон сэргээх тусгай тэмдэглэлийг холбогдох хувийн хэрэгт хийж, хариу албан бичгийг хүргүүлсэн.</p> <p>- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр: Цахим мэдээллийн сангаас эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтийг үндэслэн нийт 28 лавлагаа мэдээллийг хуульд заасан</p>	
--	---	--	--	--	---	--	--

						хугацаанд олгож ажилласан.	
2.8	Улсын бүртгэлийн хэлтэст хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах.	-	-Цахимжуулсан иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтын тоо	Иргэний улсын бүртгэл хөтөлсөн эх нотлох баримт бичгийг цахимжуулах боломжийг бүрдүүлж, тоног төхөөрөмжөөр хангасан.	Эх нотлох баримтын бүрдүүлбэрийг тухай бүр цахимжуулсан байна.	-Улсын бүртгэлийн нэгдсэн архиваас ирүүлсэн чиглэлийн дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд мэдээллийн санд эцэг, эхийн мэдээлэл бүртгэгдээгүй, зөрүүтэй тус аймгийн 202 иргэний ИУБ/ХААТР/-11, ИУБ/ХААТР/-12, ИУБ/ХААТР/-13, ИУБ/ХААТР/-14 маягтын Б талыг цахимжуулах ажлыг зохион байгуулж бүрэн цахимжуулсан. Энэ тухай илтгэх хуудсыг УБНА-т хүргүүлсэн. 2022 оны 1 дүгээр сараас бүртгэсэн ИУБ-31 маягтыг цахимжуулсан байдалд хяналт тавьж, цахимжаагүй байсан 150 бүртгэлийн маягтыг бүрэн цахимжуулж дуусгасан. Иргэний улсын бүртгэлийг хөтлөхдөө эх нотлох баримтыг цахимжуулах ажил хэвшсэн бөгөөд 2770 иргэний улсын бүртгэлийн 9837 хуудас эх нотлох баримтыг санд цахимжуулаад байна. ИУБГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу мэдээллийн санд гадаад паспортын бүртгэлийн эх нотлох баримтыг 2022.05.26-ны өдрөөс цахимжуулахаар	100%

Зорилт 3. Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.							
3.1	Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах.	-	- Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил зохион байгуулагдаж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан эсэх;	Тус хэлтсийн төрийн захиргааны нийт 27 албан хаагчдаас 2021 оны “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг цаасан хэлбэрээр гаргуулан авч, www.meduuleg.iaac.mn сайтад бүртгүүлэн ХАСХОМ-ийн нэгдсэн тайланг хүргүүлсэн; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу тус байгууллагад томилогдсон 5 албан хаагч ХАСХОМ-ийг хугацаанд нь мэдүүлж ажилласан.	-Хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.	чиглэлийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. -Хэлтсийн төрийн захиргааны жинхэнэ албан хаагч 32 ажилтнаас 2022 оны “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг цаасан хэлбэрээр гаргуулан авч, www.meduuleg.iaac.mn сайтад бүртгүүлэн ХАСХОМ-ийн нэгдсэн тайланг хүргүүлсэн; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу Хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусгавар болсон 1 албан хаагчийн ХАСХОМ-ийг хугацаанд нь мэдүүлж ажилласан. Орон нутгийн нөхөн сонгуульд итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах 8 албан хаагчдад төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийг танилцуулаж нууцын баталгааг гаргуулан авч ажилласан. Нийтийн ил тод мэдээллийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулиуд шинэчлэн батлагдсантай	100%

						холбогдуулан нийт албан хаагчдадаа танилцуулан сургалтыг аймгийн ЗДТГазар болон Тагтуулын хэлтэстэй хамтран зохион байгуулсан.	
3.2	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах.	-	-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2021 онд төлөвлөгөөт 9 удаа, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 3 удаа хяналт шалгалт хийж 45 дүгнэлт гаргасан.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажилласан байна. Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг арилгах	- Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж, 2022 оны зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж даргын зөвлөлөөр хэлэлцэн баталж төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд: -Тайлангийн хугацаанд батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын мөрөөр нийт 1945 бүртгэлд шалгалт хийж 621 бүртгэл зөрчилгүй, Хэрлэн сумын бүртгэгчийн үйл ажиллагааны гэнэтийн шалгалтын 1324 бүртгэлд хяналт шалгалт хийж 40 зөрчил илрүүлж зөрчлийг арилгуулсан.	100%
3.3						2022 оноос сумдын улсын бүртгэгч нараас иргэний улсын бүртгэл хөтлөхөд	100%

	<p>Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллах.</p>	-	<p>-Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гарах зөрчлийг бууруулсан тоо;</p>	<p>2021 онд нийт 1165 бүртгэлд хяналт шалгалт хийж, 16 зөрчил илрүүлж тухай бүр улсын бүртгэгч нараар зөрчлийг арилгуулсан. .</p>	<p>Улсын бүртгэлийн үйлчилгээ иргэн, хуулийн этгээдэд тэгш, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүрсэн байна.</p>	<p>бүрдүүлэх эх нотлох баримтыг ирген_tasag@yahoo.com тусгай мэйл хаяг нээж тус хаягаар PDF файл хэлбэрээр хүлээн авч шалгасны дараа иргэний улсын бүртгэлийн санд бүртгэсэн төлөвтэй бүртгэлийг баталгаажуулж байна. - 2770 иргэний улсын бүртгэлийн 9837 хуудас эх нотлох баримтыг санд цахимжуулсан материалын бүрдүүлбэрийг тулган шалгаж зөрчил гарсан тухай бүр зөрчлийг арилгуулж, мэдээллийн санд баталгаажуулсан. Улсын бүртгэгч нарын бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа хувийн тэмдэг ашиглалтын шаардлага хангахгүй байгаа 13 бүртгэгч /хэлтсийн 2 улсын бүртгэгч, Батноров, Батширээт, Баян-Адарга, Баянхутаг, Галшар, Хурх, Дэлгэрхаан, Бэрх, Бор-Өндөр, Тахилгат, Биндэр сумын/-ийн судалгааг нэгтгэн гаргаж, УБЕГ-ын ТГ-т тэмдэг солиулах хүсэлтийг албан бичгээр хүргүүлсэн. Хүсэлтийн дагуу 13 тэмдэг шинэчлэгдэн ирснийг</p>	
--	--	---	---	---	--	--	--

					<p>холбогдох улсын бүртгэгч нарт хүлээлцэж тэмдэглэл үйлдэн, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангасан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цаасан суурьт баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж, бүртгэлийн цахим систем /EPRS/-ийг нэвтрүүлэх явцад мэдээллийн санд зөрүүтэй, алдаатай оруулсан мэдээллийг хяналтын улмын ахлах байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ний өдрийн 1500 дугаартай дүгнэлтийг үндэслэн мэдээллийн санд 23 бүртгэлд засвар өөрчлөлтийг хийж бүртгэл хөтөлж ажилласан.</p> <p>- Улсын бүртгэлийн ерөнхий газрын тамгын газраас ирүүлсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт үзлэг хийх ажлын удирдамжийн дагуу тус хэлтэст “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт үзлэг хийх” ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг зохион байгуулж ажиллалаа. Үзлэгийг</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>хавсралт хүснэгтээр хүргүүлсэн маягтын дагуу тус хэлтсийн улсын бүртгэлийн архивт хадгалагдаж байгаа эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн Y-1817004426 дугаараас дараалсан 200 хувийн хэрэгт авагдсан нотлох баримтыг баримтыг нягтлан шалгаж цаасан баримтыг цахим мэдээллийн сантай нэг бүрчлэн тулгаж улсын бүртгэлийн дугаар, үйлчилгээний тоо, нотлох баримтын хуудасны тоо, нотолгооны ач холбогдолтой баримтын тоо, шаардлагагүй / давхардсан / баримтын нэр, тоо, ширхэг, тайлбар хэсэгт / үйлчилгээний төрөл, бүртгэсэн он, сар, өдрийг тодорхой бичих/ зэргийг нэг бүрчлэн шалгаж хүснэгтээр хүргүүлсэн.</p>	
3.4	<p>Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.</p>	-	<p>-Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо;</p>	<p>2021 онд Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 461иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 7520000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн</p>	<p>Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо буурсан байна.</p>	<p>2022 оны хагас жилийн байдлаар Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.24.1, 15.24.2, 15.24.4-т заасны дагуу 156 иргэнд хялбаршуулсан журмаар торгох шийтгэл ногдуулж прокурорын газраар хянуулж ажилласан. Орон нутгийн төсвийн дансанд торгуулийн орлого</p>	100%

						3900000 төгрөгийг төвлөрүүлсэн байна.	
3.5	Даргын зөвлөлийн болон бүх албан хаагчдын хурлын тэмдэглэл хөтөлж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих.		- Хөтөлсөн хурлын тэмдэглэлийн тоо; -Үүрэг даалгаврын тоо; -Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	2021 онд даргын зөвлөлийн 13 удаагийн хуралдаанаар хүний нөөцтэй холбоотой асуудлаар 8 асуудлыг хэлэлцэж 5 асуудлыг шийдвэрлэж, 5 үүрэг даалгавар өгөгдсөнийг 100 хувь шийдвэрлэсэн.	Тэмдэглэлийг тухай бүр нь албажуулан хурлаас өгөгдсөн үүрэг, даалгаврууд бүрэн хэрэгжсэн байна	Даргын зөвлөлийн 4 удаагийн хуралдаан зохион байгуулж хурлын тэмдэглэлийг албажуулан ажилсан. Зөвлөлийн хурлаар 3 үүрэг даалгавар өгөгдсөний хэрэгжилт 100 хувийн биелэлттэй.	100%
3.6	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох		-Хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон тоо; -Шийдвэрийн мэдээлэл; -Хэрэг маргааны судалгаа эрх зүйн хэлтэст хүргүүлсэн байдал	Хэлтсийн даргын 2021 оны 03 дугаар сарын 01-ний 6/02 дугаар “Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай тушаалаар иргэн Н.Бадамцэцэгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт тус хэлтсээс итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр улсын ахлах бүртгэгч Ц.Соёл-эрдэнэ томилогдож 2021 оны 06сарын 07-ны өдөр захиргааны хэргийн шүүх хуралд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон.	Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон.	- Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцоогүй байна. УБЕГ-ын Эрхзүйн хэлтэст хэрэг маргааны судалгааг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын СДИХАШШүүхэд нотлох баримт хүсэлт хангах тухай шүүгчийн захирамжаар 2 удаа Хэнтий Бор-Өндөр 1 дүгээр баг 49 байрны 57 тоот байрны нотлох баримт гаргаж хүргүүлсэн /УБД Ү-1804000441/	
3.7	Хэлтсийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах		- Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар хянуулсан эсэх;	2021 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө 88,46 хувьтай хэрэгжсэн	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна	2022 оны хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, даргын зөвлөлөөр хэлэлцэн	100%

	гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах.		-Гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлсэн эсэх;			баталсан. УБЕГ-ын холбогдох албан хаагчаар хянуулж зөвлөгөө авсан. УБЕГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолт, government цахим мэдээллийг ашиглан хооронд нь уялдуулан төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 35 арга хэмжээ, төлөвлөн боловсруулсан болно.	
3.8	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах.		Байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо; -Хугацаандаа байршуулсан эсэх;	2021 оны 12 сарын 25-ны байдлаар шилэн дансны цахим сайтад мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулсан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавьсан тайланг улирал тутам, хугацаанд нь УБЕГ-т хүргүүлсэн.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 оны 5 сарын байдлаар төсөв гүйцэтгэл цэсэнд 17 мэдээлэл, хөрөнгө оруулалт тендер худалдан авалт цэсэнд 17 мэдээлэл, бусад цэсэнд 25 мэдээлэл нийт 59 мэдээллийг хуулийн хугацаанд цахим болон мэдээллийн самбарт байршуулсан. 2022 оны 5 дугаар сарын байдлаар батлагдсан төсвийг 5 721 020 мянган төгрөгөөр хэмнэн ажиллаж шалтгаан тайлбарыг шилэн дансны нэгдсэн системд бүрэн мэдээлсэн. “Байгууллагын админ эрх”-ээр 1-р улирлын тайланг 2022 оны 04 дүгээр сарын 06-нд илгээж цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан.	100%

3.9	Хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах.	Урсгал төсөв, хөрөнгө оруулалт /4943863 00 төгрөг/	<p>-Санхүү, төсвийн удирдлага, төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон тайланг хуульд заасан хугацаанд нь УБЕГ-т хүргүүлэх;</p> <p>-Санхүүгийн тайлангаа аудитын байгууллагаар хянуулах;</p> <p>-Санхүүгийн сахилга, батыг хангах, өргүй, зөрчилгүй ажилласан байх.</p>	<p>2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан.</p> <p>2020 онд 537851100 сая төгрөг урсгал төсвөөс 527016200сая төгрөг зарцуулсан.</p>	<p>Байгууллагын төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулж, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж, аудитын зөрчилгүй дүгнэлт авсан байна.</p>	<p>-2021 оны 05-р сарын байдлаар 213 319 200 төгрөгийн төсөв батлагдан ирснийг Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай 207 598 180 төгрөгийн гүйцэтгэлтэйгээр зарцуулан нийт 5 721 020 төгрөгийг хэмнэж ажиллаад байна.</p> <p>Нөхөн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 8 319 000 төгрөг дээд шатны төсвийн захирагчаас, Эд хөрөнгийн бүртгэлийг сумдад хүргэх зорилгоор засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2 000 000 төгрөг шилжин ирснийг зориулалтын дагуу зарцуулах эрхийг нээлгээд байна.</p> <p>5 сарын байдлаар шуудан холбооны зардлыг 672 820 төгрөгөөр хэмнэн ажилласан. /албан бичгийн хувь хүнээр дамжуулан явуулж хэмнэж байгаа боловч хувь хүний нууц болон үнэт цаас алдагдах эрсдэлтэй байна/.</p> <p>Бичиг хэргийн зардал хүрэлцэхгүй өр үүсэх шалтгаан нь тоног төхөөрөмжийн ашиглах хугацаа дуусаж чанарын</p>	100%
-----	--	--	--	---	--	---	------

						<p>шаардлага хангахгүй албан хэрэгцээнд шаардагдах бичгийн цаас, принтерийн хор их хэмжээгээр зарцуулагдаж байгаа нь хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирч байдаг. Жич:Эд хөрөнгийн бүртгэлд / мэдүүлэг, лавлагаа, хяналтын хуудас, үйлчилгээний маягт, гэрчилгээний хуулбар/, Иргэний бүртгэлд / лавлагаа, тайлан мэдээ, ЗДТГазраас ирсэн судалгаа албан тоотын хариу/, Хуулийн этгээдийн бүртгэлд / лавлагаа, нэмэлт өөрчлөлтийг бүртгэх бүртгэлийн хуудас/, Хяналт улсын байцаагч / торгуул ногдуулахад 8 хуудас/ гэх мэт хуудас хэвлэгдэж бичгийн цаас, принтерийн хор зарцуулагддаг.</p>	
						<p>-АЗДТГазрын 176 мкв талбай бүхий 8 өрөөг түрээсийн гэрээгээр эзэмшин хэвийн үйл</p>	100%

3.10	Улсын бүртгэлийн байгууллагын байрны ашиглалт, үнэт цаас, маягт, бараа материалын хангалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулах зарцуулах, тайлагнах.	-	<p>-Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг цаг тухайд хийсэн болон ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх;</p> <p>-Үнэт цаас, маягт болон бусад бараа материал, жижиг эд хогшлын хангалтыг тасалдуулаагүй эсэх;</p> <p>-Байгууллагын үнэт цаас, маягт болон бусад бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан болон батлагдсан төсөв хэмнэсэн эсэх;</p>	2020 онд Үнэт цаас татан авах тайлагнах журмын дагуу УБЕГазраас 11862390 төгрөгийн 56037 ширхэг гэрчилгээ татан авсан. 8549487,40 төгрөгийн 44269 ширхэг гэрчилгээ маягт зарцуулсан. УБЕГазарт үнэт цаасны тайланг хугацаанд нь хүргүүлсэн.	Хагас жилээр эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өмнө байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах талаар байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гаргуулж, УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлсэн байна.	ажиллагааг ханган ажиллаж байна. Үнэт цаасыг бүртгэгч нарт хатуу дугаарын дагуу журнал хөтлөн олгож үнэт цаасны нэгдсэн программд бүртгэгч тус бүрээр хуваарилж хэвшсэн. Үнэт цаас татан авах тайлагнах журмын дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газраас 889 830 төгрөгийн 12115 ширхэг гэрчилгээ маягт татан авсан, улсын бүтгэгч нарт 1 528 800 төгрөгийн 12690 ширхэг гэрчилгээ маягт зарцуулсан байна. Сумдын болон хэлтсийн улсын бүртгэгч нараас сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон үнэт цаасны тайланг цаг хугацаанд нь авч сум бүрээр нэгтгэн УБЕГазарт хүргүүлж хэвшсэн. 2022 оны 5 сарын байдлаар хүчингүй үнэт цаас бүртгэгчийн алдаа 127 техникийн алдаа 33, нийт 160 ширхэг хүчингүй үнэт цаас гаргасан байна. Хүчингүй үнэт цаасыг өмнөх үетэй харьцуулсан судалгааг гарган ажиллаа. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогыг Хэлтсийн даргын а\12 тоот тушаалаар томилогдсон	
------	---	---	--	---	---	---	--

						ажлын хэсэг тоолж программд бүрэн шивж дуусгасан.	
3.11	Улсын бүртгэлийн архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийг нэгдсэн санд цахим хэлбэрээр хөтлөх олон нийтэд сурталчлах.		- Цахим санг үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлсэн эсэх - Цахим санд оруулсан архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийн тоо.	-	Архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтөлсөн байна.	Тус хэлтэст Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 25720, Хуулийн этгээдийн улсын бүртгэл 2521, Иргэний улсын бүртгэлийн 77612 ширхэг хувийн хэргүүд Архивын хууль тогтоомж, журмын дагуу хадгалагдаж байна. Мөн УБЕГ-ын нэгдсэн сангийн цахим архиваас лавлагаа хуулбарыг иргэн хуулийн этгээдэд олгож байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд цаасан архивын эх нотлох баримтаас лавлагаа хуулбар олгож байна.	100%
3.12	Архивын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах.	-	- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2021 онд Иргэний баримтын архивын хувийн хэргийг эксель файл болгон шивэх ажил үргэлжлэн хийгдэж байгаа бөгөөд одоогийн байдлаар 99 хувьтай явагдаж байна. Төрөлтийн маягтуудыг шивэх ажил үлдээд байна. “Эд хөрөнгийн улсын бүртгэлийн архивын баримтад газраас бусад үл хөдлөх- 7852, газрын-14887 нийт 22739 хувийн хэргийн цаасан баримтыг цахим мэдээллийн сантай тулгаж 42 хувийн хэргийн бүртгэлийн зөрчлийг	Архивын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хангагдсан. байна.	-Иргэний баримтын архивын үйл ажиллагааны 12 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 2019 оноос хойших бүртгэлийн дэвтэр, нотлох баримтын хадгаламжийн нэгжийн хаягжуулалтыг шинэчилсэн. Мөн архивын өрөөний галын буланг шинэчлэх ажлыг хийсэн. -Эд хөрөнгийн архивын үйл ажиллагааны 6 заалт бүхий төлөвлөгөөг	100%

				хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж арилгасан. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн бүртгэлийн 761 архивын баримтад тоо бүртгэл хөтлөж 65 хувьтай тооллого явагдсан.		гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн баримтын архивын тооллогыг дүн, илтгэх хуудсыг Хэлтсийн дарга болон УБЕГ-ын ЭХЭУБГ азарт хүргүүлсэн.	
3.13	Тамга, тэмдэг хэрэглэх эрх бүхий этгээдээс хураалга сан тамга тэмдгийг төрийн архивт шилжүүлэн хадгалуулах	-	-Төрийн архивт шилжүүлсэн тамга тэмдгийн тоо,	“УБЕГ-ын даргын тушаалаар 1 индекс, 1 код батлагдсан.	Хуулийн этгээдийн хэлбэрийн индексийг батлуулж, мөрдсөн байна.	-Төрийн байгууллагын оноосон нэр өөрчлөгдсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 7 тэмдгийг хураан авч тамга тэмдгийн бүртгэл хөтөлж хяналтын дугаар олгосон. Тамга тэмдгийг акт үйлдэн Аймгийн төрийн архивт шилжүүлсэн.	100%
3.14	Байгууллагын ББНШАЗК-ын үйл ажиллагаанд хяналт тавих, хэлтсийн 2022 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлын зохион байгуулах	-	-Жагсаалтыг эцэслэн батлуулсан эсэх; -Устгасан баримт бичгийн тоо;	-	Жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.	УБЕГ-ын дэргэдэх ББНШАЗК-ын 2022.02.10-ны өдрийн 01 хуралдааны шийдвэрээр иргэний үнэмлэх дахин авах өргөдөл 613, ИУБ-21 маягт 4524, DVD-1498ш, хадгалах хугацаа нь дууссан баримтуудыг 2022.03.04-ний өдөр байгууллагын ББНШК-ын гишүүд устгалыг хийсэн. 2022 онд хадгалах хугацааны жагсаалтын дагуу хадгалах хугацаа дууссан 5274 ш ИУБ-21 маягыг устгалд оруулах	100%

						саналыг холбогдох газарт хүргүүлсэн.	
Зорилт 4. Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.							
4.1	Аймаг, сумын ИТХ, ЗДТГ болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах		- Санал тавьж шийдвэрлүүлсэн эсэх;	ЗДТГазраас төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, үйлчилгээний стандарт, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг хангах зорилгоор тус хэлтсийн үйлчилгээний зааланд нийт 4,8 сая төгрөгийн 8 үнэлгээний төхөөрөмж суурилуулсан. Улсын бүртгэгч бүр үйлчилгээ үзүүлсний дараа үйлчлүүлэгчдээс төхөөрөмжөөр үнэлгээ авч байна. “Улсын бүртгэл-80 жил” аяны удирдамжийн дагуу 2015-2020 оны тус хэлтсийн товч танилцуулга, ном товхимол мэдээллийг бэлтгэн хэвлүүлэх 3,5 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн.	Тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлсэн байна.	-Хэнтий аймгийн засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн А/281 тоот захирамжаар Хэнтийн Хэнтий арга хэмжээний хүрээнд хөдөө орон нутгийн иргэдэд “Цахим гарын үсэг” олгох аян, “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цогц үйлчилгээ- нээлттэй газрын харилцаа орон нутаг” өдөрлөг зохион байгуулахад зориулж 2 000 000 / хоёр сая / төгрөгийн дэмжлэг авч ажилласан. Баянмөнх сумын Улсын бүртгэгчид Засаг даргын тамгын газраас албан хэрэгцээнд зориулаж нөүтбоок комътерийн дэмжлэг үзүүлсэн.	100%
4.2	Улсын бүртгэлийн асуудлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан	-	- Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь; -Мэдээ тайланг үнэн зөв гаргасан байдал	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 2021 оны шийдвэрлэлт 100%.	Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайланг УБЕГ, АЗДТГ-ын “иргэдээ сонсьё” 70563111 утсанд ирүүлсэн	-Тайлангийн хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой 37 өргөдөл, хүсэлт ирсний 35 нь иргэдээс, 2 хэлтсийн албан хаагчдаас ирсэн байна. Ирүүлсэн өргөдөл,	100%

	бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд хянан шуурхай шийдвэрлэх				өргөдөл гомдлыг хугацаанд нь хүргүүлсэн байна	хүсэлтийг холбогдох хууль журмын дагуу 100 хувь шийдвэрлэж хариу өгч ажилласан. Улсын ахлах бүртгэгч АЗДТГ-ын тусгай дугаарын 70563111 утсаар ирүүлсэн 2 иргэний өргөдлийн хариуг албан бичгээр шийдвэрлэсэн. -Хэлтсийн улсын бүртгэгч нарын санал хүсэлтийн дэвтрээр 2 талархал бичигдсэн.	
Зорилт 5. . Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана..							
5.1	Хэлтсийн 2022 онд зохион байгуулах сургалт, мэдээллийн болон үндсэн ажлаас гадуур хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах.	-	-Сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулсан эсэх -Сургалтуудыг хуваарийн дагуу зохион байгуулсан эсэх; -Төлөвлөгөөний явц, биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган танилцуулах, дүгнэх. - Сургалтанд хамруулсан албан хаагчдын тоо	Хэлтсийн 2021 оны сургалт мэдээллийн төлөвлөгөөний дагуу ZOOM программ ашиглан 20 удаа ажил хэргийн уулзалт, чиглэл зөвлөмж өгөх, сургалт зохион байгуулах зорилгоор мэдээлэл хийх хуваарийг улирлаар гарган сумдын улсын бүртгэгч нартай цахимаар холбогдож зохион байгуулсан. Байгууллагын цахим хуудсаар улсын бүртгэлтэй холбоотой 200 мэдээ, мэдээллийг тархаан ажилласан бөгөөд үүнээс видео мэдээлэл-45, зурагт мэдээ мэдээлэл-155, иргэний улсын бүртгэлтэй холбоотой 78 мэдээ, эд хөрөнгийн 14, хуулийн улсын бүртгэлтэй зурган - 14 мэдээ бусад мэдээлэл-	Сургалтын үйл ажиллагаа болон бусад холбогдох төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Долоо хоног бүрийн Мягмар гаригт АЗДТГ-аас зохион байгуулж буй хууль, эрх зүйн сургалт, УБЕГ-аас зохион байгуулж буй чиглэлийн сургалтууд, Пүрэв гариг бүрт Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 4:7:10 вэбинар сургалтуудад албан хаагчид тогтмол хамрагдаж байна. Мөн үндсэн ажлаас гадна хийгдэх ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу 3 удаа сургалтыг зохион байгуулсан. ZOOM мэдээллийн цагийн хуваарийн дагуу 14 хоног тутамд сумдын улсын	100%

				<p>94 мэдээллийг тархаан иргэдэд хүргэсэн. Нийт 7 удаагийн иргэд рүү чиглэсэн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 225 иргэнд улсын бүртгэлтэй холбоотой мэдээ, мэдээллээр ханган ажилласан байна.</p>		<p>бүртгэгч нарт мэдээ, мэдээлэл, чиглэл өгч байна.</p> <p>Иргэд, байгууллага руу чиглэсэн сургалт, мэдээллийн ажлын хүрээнд тоон гарын үсэг олгохтой холбогдуулан Төрийн банк, Цагдаагийн газар, ШШГГ, ШША, Мэдээлэл холбоо, сүлжээний газар, Нэгдсэн эмнэлэг, Боловсрол газрын албан хаагчдад улсын бүртгэлийн чиглэлээр мэдээлэл өгсөн. Мөн “Нээлттэй өдөрлөг”-өөр 271 иргэнд улсын бүртгэлийн чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.</p>	
5.2	<p>Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах</p>	-	<p>-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо; -Заавартай танилцсан албан хаагчийн тоо;</p>	<p>2021 онд 16 удаагийн сургалтад болон бусад байгууллагаас зохион байгуулсан 15 удаагийн сургалтад давхардсан тоогоор 982 албан хаагч, УБ-ийн хэлтсийн итгэмжлэгдсэн ажилтанг тус тус бүрэн хамруулсан.</p>	<p>Албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.</p>	<p>-Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 онд зохион байгуулах 17 заалт бүхий сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж баталсан. Төлөвлөгөөний дагуу холбогдох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажилласан. 2018 оноос хэрэгжиж эхэлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд зааснаар 5 жилийн хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 19 дүгээр зүйл 19.1-д заасан шаардлагыг хангаж ажиллах үүднээс Орхон Их Сургуулийн Хууль зүйн</p>	100%

					<p>салбар сургуульд 9 сум, 2 тосгон, хэлтсийн 2, нийт 13 улсын бүртгэгч нар эрх зүйн эчнээ ангид суралцаж, 1-р курсээ ажилттай төгссөн.</p> <p>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, улсын бүртгэгч нарт дэмжлэг үзүүлэх талаар АЗДаргад хүсэлт хүргүүлж 13 албан хаагчдын сургалтын төлбөрийн 50%-д дэмжлэг үзүүлэхээр болсон.</p> <p>УБЕГазар, Хэнтий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаа, бүртгэлийн статистик мэдээ, мэдээллийн талаар цахим орчинд мэдээ, мэдээллийг тархааж бүртгэлийн нээлттэй, ил тод байдлыг ханган ажилласан.</p> <p>УБЕГазар, Улсын бүртгэлийн хэлтэс болон бусад газраас зохион байгуулсан цахим болон танхимын 34 удаагийн сургалтад давхардсан тоогоор 495 албан хаагчид хамрагдсан.</p> <p>Төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдэд 22 удаагийн 1324 иргэнд мэдээлэл өгч сургалт зохион байгуулж улсын бүртгэлийн үйлчилгээг сурталчлан ажилласан./Дэлгэрэнгүйг сургалтын тайлангаас үзнэ үү./</p>	
--	--	--	--	--	--	--

5.3	Байгууллагын ёсзүйн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах	-	- Үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Байгууллагын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хагас болон бүтэн жилээр холбогдох газарт тайлагнасан.	Зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжсон байна.	-Ёс зүйн зөвлөлийн 2022 онд хийх 11 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн ZOOM мэдээллийн цагаар ёс зүй, сахилга, хариуцлагын талаар зөвлөмж, чиглэл өгч ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2021 оны тайланг, хавсралт 3 хүснэгтийн дагуу гарган АЗДТГ-т хүргүүлсэн. Ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах талаар нийт улсын бүртгэгч нарт албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Албан хаагчдаар Ёс зүйн дүрмийн баталгаа гаргуулан хувийн хэрэгт хавсаргасан. Тайлангийн хугацаанд албан хаагчдын ёс зүйтэй холбоотой гомдол гараагүй.	100%
5.4	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих.		-Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь; -Ёс зүйн арга хэмжээ авагдсан албан хаагчдын тоо;	2021 онд улсын бүртгэгч нарыг хууль эрх зүйн мэргэжил арга зүйгээр 100 хувь ханган ажилласан. Бүртгэгчийн үйл ажиллагаа, ёс зүйтэй холбоотой зөрчил дутагдал гараагүй.	Үйл ажиллагаандаа дүрэм, журмыг мөрдөж, стандартын зөрчил гараагүй байна	-Ёс зүйн зөвлөлийн 2022 онд зохион байгуулах 12 заалт бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулж батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 2 дугаар улирлын байдлаар 3 сургалтыг албан хаагчдад зохион байгуулаад байна. Үүнд: “Үнэлгээний төхөөрөмж ашиглах журам”-ын танилцуулга, “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн танилцуулга, “Ёс зүй ба ёс суртахууны тухай	100%

						ойлголт” сэдвээр presentation хичээл онлайнгаар улсын бүртгэгч нарт танилцуулсан.	
5.5	Албан хаагчдын ниймгийн баталгааг хангах чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулах.		-2-оос доошгүй албан хаагчийг хамруулсан байна.	УБЕГ-ын хөдөлмөрийн дотоод журмын дагуу 2 албан хаагч, бусад холбогдох хуулийн дагуу 1 албан хаагчид мөнгөн тэтгэмж олгогдсон.	Албан хаагчдын нийгмийн баталгаанд дэмжлэг үзүүлсэн байна.	2021-2022 оны хичээлийн жилд Орхон их сургуулийн Хууль-зүйн салбарын сургуульд нийт 13 албан хаагчийг Эрхзүйн эчнээ хөтөлбөрт суралцуулж байгаа бөгөөд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх хүсэлтийг Аймгийн засаг даргад уламжилж 50 хувийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 4/1300 албан бичгээр шийдвэрлүүлсэн. Хяналтын улсын байцаагч О.Ганбаатар, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч О.Энх-Ариун нарын ар гэр бүл болон эрүүл мэндийн шалтгаанаар УБЕГ-ын даргын Б/264, Б/304 тушаалаар 1 сарын цалинтай чөлөө олгосон. 8 албан хаагчдад цалингийн шатлал нэмүүлсэн. 2 албан хаагчдад 500 000 буцалтгүй тусламж олгосон. Хэлтсийн албан хаагчдын 77 хүүхдийг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.	90%